

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын НААУ ОНӨ ХХК-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2024/06/НА-СТА-ОНА

| | |
|---|--|
| Цахим хуудас: www.dornogovi@audit.gov.mn Дорноговь аймаг Сайншанд сум 2024 он | Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 261665, 70522734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Ахлах аудитор/аудитор: Д.Сайнжаргал Утас: 99080493 Цахим хаяг: info.iedca@gmail.com Интакс Эксперт Ди Си ХХК-ийн захирал: Д.Сайнжаргал Утас: 99080493 Цахим хаяг: info.iedca@gmail.com |
|---|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Компани, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Компанийн гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлт.....
4. Аудитын тайлан
- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 4.4 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|--------|---|
| СТОУС | Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2024.03.15 № 1-б/302

танай _____-ны № _____-т

**ЗАМЫН-ҮҮД НААҮ
ОНӨХХК-ИЙН ЗАХИРАЛ
Ө.НАРАНТУЯА ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Замын-Үүд НААҮ ОНӨ” ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Замын-Үүд НААҮ ОНӨ” ХХК -ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно. Замын-Үүд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хуралдааны 2023 оны 10/62 тогтоолоор компанийн дүрэмд өөрчлөлт оруулсан байна

Аудиын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2023 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, хөрөнгийн үр ашигтай зарцуулалт, баримтжуулалт хөрөнгө зарцуулалтын ил тод байдал, худалдан авах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулсан эсэх, хөрөнгийн удирдлага зохион байгуулалт зэргийг гол асуудал гэж үзлээ.

Тайлант жилд нийт 101,543 юаны барааг худалдан авсан боловч гаалийн албанд мэдүүлээгүй.

0100000002

Энэ нь Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13.1 “Дараах нөхцөлийг нэгэн зэрэг хангасан зардлыг албан татвар ногдох орлогоос хасаж тооцно”, 13.1.4 “доор дурдсан бараа, ажил, үйлчилгээний зардал Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт, импортын бараанд татвар ногдуулж, гаалийн байгууллагад төлсөн тухай баримтаар баталгаажсан байх” гэсэн заалттай нийцэхгүй, мөн үнэн зөв байдлын батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Батлагдсан орон тоонд нярвын орон тоо байдаг хэдий ч няравгүй, нягтлан бодогч нь бараа материалын тайлангаа өөрөө гаргаж байна. Гэтэл нягтлан бодогч нь нярвын тайланд хяналт тавьж ажиллах ёстой байдаг. Иймээс ашиг сонирхлын зөрчил үүсэх магадлалтай байна.

Бусад асуудлын хэсэг

АДБОУС 2706.10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | /төгрөгөөр/ | |
|-----------------|---|-------------------------|-------------------------|
| | | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
| 1 | ХӨРӨНГӨ | | |
| 1.1 | Эргэлтийн хөрөнгө | | |
| 1.1.1 | Мөнгө, түүнгэй адилтгах хөрөнгө | 422,830.16 | 33,155,067.94 |
| 1.1.2 | Дансны авлага | 974,464.02 | 27,217,294.00 |
| 1.1.3 | Татвар, НДШ – ийн авлага | 256,302.05 | 119,373.26 |
| 1.1.4 | Бусад авлага | 2,375,697.89 | 458,608.81 |
| 1.1.6 | Бараа материал | 24,790,000.00 | 9,355,965.00 |
| 1/1/11 | Эргэлтийн хөрөнгийн дүн | 28,819,294.12 | 70,306,309.01 |
| 1.2 | Эргэлтийн бус хөрөнгө | | |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 2,530,035,197.48 | 2,285,896,398.36 |
| 1.2.8 | Бусад эргэлтийн бус хөрөнгө | 99,875,000.00 | 99,875,000.00 |
| 1/2/10 | Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 2,629,910,197.48 | 2,385,771,398.36 |
| 1.3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 2,658,729,491.60 | 2,456,077,707.37 |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 2,570,715.00 | 3,000,000.00 |
| 2.1.1.2 | Цалингийн өглөг | 30,000.00 | 502,902.34 |
| 2.1.1.3 | Татварын өр | 592,436.55 | 293,039.78 |
| 2.1.1.13 | Богино хугацаат өр төлбөрийн дүн | 3,193,151.55 | 3,795,942.12 |
| 2.2 | Өр төлбөрийн нийт дүн | 3,193,151.55 | 3,795,942.12 |
| 2.3 | Эздийн өмч | | |
| 2.3.2 | - хувийн | 4,894,481,140.10 | 5,017,700,907.05 |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг | (2,238,944,800.05) | (2,565,419,141.80) |
| 2/3/11 | Эздийн өмчийн дүн | 2,655,536,340.05 | 2,452,281,765.25 |
| 2.4 | ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН | 2,658,729,491.60 | 2,456,077,707.37 |

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | /төгрөгөөр/ | |
|---------------|---|---------------------------|---------------------------|
| | | 2022 оны 12 сарын 31 өдөр | 2023 оны 12 сарын 31 өдөр |
| 1 | Борлуулалтын орлого (цэвэр) | 735,166,100.00 | 1,128,682,429.00 |
| 3 | Нийт ашиг (алдагдал) | 735,166,100.00 | 1,128,682,429.00 |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 817,434,400.00 | 1,432,388,228.05 |
| 11 | Санхүүгийн зардал | - | 389,408.37 |
| 12 | Бусад зардал | - | 2,456,349.30 |
| 18 | Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) | (82,268,300.00) | (306,551,556.72) |
| 19 | Орлогын татварын зардал | - | - |
| 20 | Татварын дараах ашиг (алдагдал) | (82,268,300.00) | (306,551,556.72) |
| 22 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | (82,268,300.00) | (306,551,556.72) |
| 24 | Орлогын нийт дүн | (82,268,300.00) | (306,551,556.72) |

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

| № | ҮЗҮҮЛЭЛТ | Өмч | Хуримтлагдсан ашиг | Нийг дүн |
|----|--|------------------|--------------------|------------------|
| 1 | 2021 оны 12 -р сарын 31 - ний үлдэгдэл | 4,545,232,300.00 | (2,156,676,500.07) | 2,388,555,799.93 |
| 4 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | - | (82,268,300.00) | (82,268,300.00) |
| 6 | Өмчид гарсан өөрчлөлт | 349,248,840.10 | - | 349,248,840.10 |
| 9 | 2022 оны 12 -р сарын 31 - ний үлдэгдэл | 4,894,481,140.10 | (2,238,944,800.07) | 2,655,536,340.03 |
| 10 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | - | (19,922,785.00) | (19,922,785.00) |
| 12 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | - | (306,414,627.93) | (306,414,627.93) |
| 14 | Өмчид гарсан өөрчлөлт | 123,219,766.95 | - | 123,219,766.95 |
| 17 | 2023 оны 12 -р сарын 31 - ний үлдэгдэл | 5,017,700,907.05 | (2,565,282,213.00) | 2,452,418,694.05 |

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | 2022 оны 12 сарын 31 өдөр | 2023 оны 12 сарын 31 өдөр |
|---------------|--|---------------------------|---------------------------|
| 1 | Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 1.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 735,166,100.00 | 1,241,557,386.90 |
| | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 54,652,700.00 | 1,239,744,299.90 |
| | Татаас, санхүүжилтийн орлого | 680,353,000.00 | - |
| | Бусад мөнгөн орлого | 160,400.00 | 1,813,087.00 |
| 1.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 737,365,900.00 | 1,206,074,149.12 |
| | Ажиллагчдад төлсөн | 529,952,400.00 | 601,458,093.88 |
| | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 127,188,000.00 | 169,955,845.90 |
| | Бараа материал худалдан авахад төлсөн | 68,754,000.00 | 157,273,745.00 |
| | Ашиглалтын зардалд төлсөн | 11,471,500.00 | 23,532,624.31 |
| | Татварын байгууллагад төлсөн | - | 174,487,708.66 |
| | Даатгалын төлбөрт төлсөн | - | 2,013,823.00 |
| | Бусад мөнгөн зарлага | - | 77,352,308.37 |
| 1.3 | Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний | (2,199,800.00) | 35,483,237.78 |
| 2.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | - | 2,550,000.00 |
| | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | - | 2,550,000.00 |
| 2.3 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн | - | (2,550,000.00) |
| 3.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | - | 201,000.00 |
| | Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | - | 201,000.00 |
| 3.3 | Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн | - | (201,000.00) |
| 4.1 | Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | (2,199,800.00) | 32,732,237.78 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 2,622,630.16 | 422,830.16 |
| 6 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 422,830.16 | 33,155,067.94 |

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 143.1 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 143.1 сая төгрөгийн алдааг залруулга хийлгэж ажиллалаа.

Залруулсан алдаа:

2022 оны санхүүгийн тайлангийн эцсийн үлдэгдэл нь буруу байснаас Өмчид гарсан өөрчлөлтийн дансанд 123.2 сая төгрөгийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга 19.9 сая төгрөгийн нийт 143.1 сая төгрөгийн алдааг залруулсан байна.

Аудитаар нийт 4 зөрчил илэрч 4 зөвлөмж өгсөн

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлээгүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Гадаад худалдан авалттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант жилд нийт 101,543 юаны барааг худалдан авсан боловч гаалийн албанд мэдүүлээгүй.

Энэ нь Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13.1.Дараах нөхцөлийг нэгэн зэрэг хангасан зардлыг албан татвар ногдох орлогоос хасаж тооцно... 13.1.4.доор дурдсан бараа, ажил, үйлчилгээний зардал Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт, импортын бараанд татвар ногдуулж, гаалийн байгууллагад төлсөн тухай баримтаар баталгаажсан байх,,,,,гэсэн заалттай нийцэхгүй, мөн “үнэн зөв байдлын батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах

2. Нийгмийн даатгал, цалинтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант жилийн цалингийн хүснэгт, нийгмийн даатгалын тайланг тулган шалгахад 1-10 р саруудад 18,4 сая төгрөгийн зөрүүтэй байна. Энэ нь нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн холбогдох заалтыг зөрчиж байгаа бөгөөд үнэлгээ ба үнэн зөв байдлын батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Тайлант сард бодогдсон цалин хөлсийг нийгмийн даатгалын тайланд үнэн зөв алдаагүй тайлагнаж байх.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

3. Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Батлагдсан орон тоонд нярвын орон тоо байдаг хэдий ч няравгүй, нягтлан бодогч нь бараа материалын тайлангаа өөрөө гаргаж байна. Гэтэл нягтлан бодогч нь нярвын тайланд хяналт тавьж ажиллах ёстой байдаг. Иймээс ашиг сонирхлын зөрчил үүсэх магадлалтай байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Батлагдсан орон тоогоор ажиллаж, ашиг сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлж ажиллах

4. Төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК нь эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлуулаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Байгууллагын жилийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлуулан ажиллах

Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад
талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс Залруулсан | |
|--|------------|-------------------|-----------------------------------|----------|--------------------------|----------|-------------------|-------------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 2022 оны жилийн эцсийн тайлан зөрүүтэй тайлагнагдаж, Э тайлан системд алдаатай шивэгдсэн тул тайланг үнэн зөв тайлагнаж өмчинд гарсан өөрчлөлт, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөөлөл дансанд тохируулга хийж залруулсан байна. | 1 | 143,142.55 | | | | | 1 | 143,142.55 |
| ДҮН | 1 | 143,142.55 | 0 | - | 0 | - | 1 | 143,142.55 |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|--|-------------|---|---------------|----------|-----------------|----------|----------|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Тайлант жилд нийт 101543 юаны барааг худалдан авсан боловч гаалийн албанд мэдүүлээгүй. | 1 | | | | | | 1 | |
| Няравын орон тоотой хэдий ч нягтлан бодогч бараа материалын орлого авч зарлага гарган анхан шатны баримтыг боловсруулан тайлан бэлтгэж байгаа нь нягтлан бодох бүртгэлийн хяналтыг сулруулж байна. | 1 | - | | | | | 1 | - |
| Тайлант жилийн цалингийн хүснэгт, нийгмийн даатгалын тайланг тулган шалгахад 1-10 р саруудад 18,4 сая төгрөгийн зөрүүтэй байна. | 1 | | | | | | 1 | |
| Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг | 1 | | | | | | 1 | |
| ДҮН | 4 | | - | - | - | - | 4 | |